



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/310

Булган сум

Иргэдэд хууль, эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт" хөтөлбөр, "Хөтөлбөр төлөвлөгөө арга хэмжээний зардлын хуваарийг шинэчлэн батлах тухай" аймгийн Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2026 оны 05 дугаар сард иргэдэд хууль, эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны зардалд "Амар тайван Булган" хөтөлбөрийн санхүүжилтээс 9,516,250 (есөн сая таван зуун арван зургаан мянга хоёр зуун тавь) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг "Амар тайван Булган" хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3. "Амар тайван Булган" хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэх ажил, хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА

Д. ПҮРЭВ-ОЧИР



6326010426

Аймгийн Засаг даргын 2026 оны  
04 дүгээр сарын 28-ны/ний өдрийн  
А/310 дугаар захирамжийн хавсралт

“АМАР ТАЙВАН БУЛГАН” ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛААС САНХҮҮЖҮҮЛЭХ  
АЖИЛ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| д/д      | Хөрөнгө зарцуулах зориулалт  | Зохион байгуулах нэгж   | Хэмжээ                                   | Мөнгөн дүн /төгрөгөөр/ |
|----------|--|---|--|------------------------|
| 1        | 2  | 3   | 4  | 5                      |
| 1        | Булган аймгийн 16 сум 1 тосгоны иргэд, хүүхэд залуучуудад чиглэсэн хуульчийн “Про-Боно 2026” өдөрлөгийг “Нэг сум-нэг агт” аянтай уялдуулан зохион байгуулах зардал | Хууль эрх зүйн хэлтэс, эрх зүйн багийн гишүүн байгууллагууд, Хуульчдын холбоо, Тэшиг сум дахь Хилийн цэргийн 0286 дугаар анги | 16 сум 1 тосгонд зохион байгуулах зардал | 4,636,250              |
| 2        | Алслагдсан цэгүүд болон багуудын орох, гарах цэгт камерын холболт хийх, тээврийн хэрэгслийн дугаар танигчтай камерыг байршуулж холбох                              | Цагдаагийн газар, Телекамерын хяналтын дэд төв  | Булган суманд хийгдэх зардал             | 3,000,000              |
| 3        | “Мотоцикл-Хамгаалах малгай” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах   | Цагдаагийн газар  | Хяналт шалгалтын зардал                  | 680,000                |
| 4        | Үе тэнгийн сургагч багшийн ажлын хөлс  | Хууль эрх зүйн хэлтэс, “Булганы өнгө” ТТБ   | Сургагч багшийн зардал                   | 200,000                |
| 5        | Зөвлөх үйлчилгээний ахмад хуульчдын ажлын хөлс   | Шүүхийн ахмад хуульчдын холбоо  | Ахмад Хуульчийн ажлын зардал             | 1,000,000              |
| Нийт дүн |  |   | 9,516,250                                |                        |

--о00о--